Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

Төрийн захиргааны удирдлагын газар

# 2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл-ийн хувь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | Өөрийн үнэлгээ | ХШҮ |
| Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | | | | | | | | | |
| 4.1. | Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарт хамаарах арга хэмжээ болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнана. | - | - | - | - | | Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарт хамаарах арга хэмжээ болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хууль тогтоомжид заасан хугацаанд тайлагнаж албан бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. | 100% | 90 % |
| 4.1.1 | Хууль тогтоомж, | - | Хууль, тогтоомж, | 2024 оны биелэлтийн | Холбогдох заалтын | Холбогдох заалтын | Боловсролын салбарт мөрдүүлэхээр батлагдсан хууль | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтоол шийдвэрийн биелэлтийг тайлагнах; | | тогтоол шийдвэрийн тоо | хувь | хэрэгжилт хангагдсан байна. | хэрэгжилт хангагдсан байна. | тогтоомж, тогтоол шийдвэрийн 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийг 527, 2025 оны 01 дүгээр сарын хэрэгжилтийг 266 заалтаар тус тус холбогдох газар хэлтсээс авч нэгтгэн ХШҮДАГ-т хуулийн хугацаанд хүргүүлсэн. Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 10 дугаар хуралдааны тэмдэглэлд Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр бүрэн хэрэгжсэн, тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан, чиг үүрэгт хамааралгүй, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, холбогдох хууль тогтоомжийн үйлчлэл дуусгавар болсон гэж дүгнэсэн хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 1357 заалтыг хяналтаас хасах асуудлыг зохих журмын дагуу зохион байгуулахыг Монгол улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаярт даалгасны дагуу 2 дугаар сарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг гаргах цахим систем нээгдээгүй. Үүнтэй холбоотойгоор Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын 3-р хавсралтаар "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам" батлагдаж, журмын тайлагнах цаглабарын 1 дэх хэсэгт Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг улирал бүр цахим системээр | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тайлагнаж байх талаар тусгасан байна. Журмын дагуу 2025 оны 1-р улиралд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг 232 заалтаар яамны 10 газар, 8 хэлтэс, харьяа байгууллагаас авч нэгтгэн хуулийн хугацаанд ХШДАГ-т хүргүүлсэн байна. Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд хангалтгүй буюу 0-30 хувьтай үнэлэгдсэн Засгийн газрын тогтоолын 11 заалт, ЗГ-ын хуралдааны тэмдэглэлийн 9 заалт, ЗГ-ын албан даалгаврын 1 заалтын биелэлтийг 2025 оны 1-р улирлын байдлаар холбогдох нэгжүүдээс тайлбар буюу хэрэгжилтийн дахин гаргуулж ХШҮДАГ-т 05 дугаар сарын 12-ны өдөр хүргүүлсэн. Мөн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг 2025 оны 1-р улирлын байдлаар гаргах явцад буруу хуваарилалт хийсэн 40 гаруй хуулийн заалтыг цахим системд зөв болгож хуваариллаа. /Сар, улирлын хэрэгжилтийг https://meds.igovernment.mn/l | | |
| 4.1.2 | Дээд байгууллагаас батлагдан ирсэн тогтоол шийдвэрийг бүртгэлжүүл | - | 1.Бүртгэлжүүлсэн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн тоо 2. Тайлангийн | 1.2024 оны жилийн эцсийн байдлаар 527 хууль тогтоомжийг бүртгэлжүүл | Яамны удирдлага, нийт албан хаагчид мэдээллээр хангагдсан байна. | Яамны удирдлага, нийт албан хаагчид мэдээллээр хангагдсан байна. | Дээд газраас батлагдаж ирсэн Ерөнхий сайдын захирамж-13, Засгийн газрын тогтоол -21, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл -43-г бүртгэлжүүлж, ТНБД болон ТЗУГ-ын дарга нарт танилцуулж, холбогдох газар, | 90% | 90 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | эх, тайланг тогтоосон хугацаанд нэгтгэж холбогдох газарт хүргүүлэх; | | тоо | сэн. 2.2024 оны тайлангийн тоо | Тайланг нэгтгэн хугацаанд хүргүүлсэн байна. | Тайланг нэгтгэн хугацаанд хүргүүлсэн байна. | хэлтэст хүргүүлсэн. Мөн яамны able цахим системийн тогтоол шийдвэрийн сан, олон нийт дээр байршуулж албан хаагчдыг мэдээллээр хангаж ажилласан. /Able-ийн олон нийт, тогтоол шийдвэрийн сан буюу https://intranet.gov.mn/main.php?p =cHiVbGlj-ээс Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийг харах/ Одоогоор дээд газраас ирсэн 40 орчим шийдвэрийг /холбогдох нэгжид шилжүүлсэн байна. Монгол Улсын Засгийн Газраас 2025 оныг "Залуучуудын хөгжлийг дэмжих жил" болгон зарласантай холбоотой "Залуучуудын хөгжлийг дэмжих жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах саналыг ССАЖЗЯ-д 2/244 албан бичгээр, Улаанбаатар хотын Жанжин Сүхбаатарын талбайд 2025 онд зохион байгуулах арга хэмжээ, үйл ажиллагааны мэдээллийг 1/652 албан бичгээр ЗГХЭГ-т, Өмнийн говийн бүсийн хөгжлийн зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах саналыг 1/423 албан бичгээр Боомтын сэргэлтийн Үндэсний хороонд, УИХ-ын 36 дугаар тогтоол, уг тогтоолын хавсралтаар баталсан төлөвлөгөөний арга хэмжээний хэрэгжилтийг холбогдох газруудаас авч нэгтгэн УИХ-ын | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | гишүүн Ж.Батжаргалд Боловсролын сайдын 1/1500 албан бичгээр 4 зорилтын хүрээнд 11 арга хэмжээний хэрэгжилтийг тус тус хүргүүллээ. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах саналыг 2/929 албан бичгээр, “Замын хөдөлгөөнд оролцогчийн мэдлэг хандлагыг сайжруулах, замын хөдөлгөөнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах нь" сэдвийн хүрээнд Боловсролын сайдын тавих ppt-г бэлтгэж тус тус ЗТ-ийн сайдад, Монгол Улсын Нээлттэй Засгийн Түншлэлийн 2024-2027 оны үйл ажиллагааны Үндэсний 5 дугаар төлөвлөгөө"-нд туссан арга хэмжээний хэрэгжилтийн 2025 оны хагас жилийн тайланг ЗГХЭГ-т 1/2363 албан бичгээр тус тус хүргүүллээ.<br>Хавсралт: 8 файл | | |
| 4.1.3 | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг тайлагнах; | - | Зорилтын тоо, шалгуур, хэрэгжилтийн хувь | 2024 оны тайлан | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг хугацаанд нь тайлагнаж, хэрэгжилт хангагдсан байна. | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг хугацаанд нь тайлагнаж, хэрэгжилт хангагдсан байна. | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн 2024 оны жилийн эцсийн тайлангийн үнэлгээнд ЗГХЭГ-аас аудит хийсэн бөгөөд тус аудитэд шаардлагатай мэдээ мэдээлэл, судалгааг гаргаж өгөх ажлыг хийсэн.Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл | 90% | 90 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажиллагааны хөтөлбөрийн зорилтын тайланг гарган ХШҮДАГ хүргүүлсэн. Улсын үнэлгээний чадавхын индекс (УҮЧИ) тогтоох асуумжийн 62 хариултыг боловсруулан бөглөж системээр илгээсэн.<br>Хавсралт: 2 файл | | |
| 4.1.4 | Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах; | - | Зорилтын тоо, шалгуур, хэрэгжилтийн хувь | 2024 оны тайлан | Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнасан байна. | Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнасан байна. | 1. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийн тайланд аудит хийсэн бөгөөд тус аудитад мэдээ мэдээлэл цаг тухайд нь гаргаж өгөх тайлангийн шаардлагатай нотлох баримт, нэмэлт тайлбарыг нэгтгэн хүргүүлэх ажлыг гүйцэтгэсэн. 2. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний санхүүжилтийн эх үүсвэр, гүйцэтгэлийн тайлан гарган ХШҮДАГ-т илгээсэн. 3. Улсын их хурлын 37 дугаар тогтоолд тусгагдсан Хүний эрх, эрх чөлөөг хангах хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг гарган хүргүүлсэн. 4. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийгдсэн аудитын үнэлгээнд нэмэлт мэдээлэл бэлтгэн илгээсэн. 5. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөртэй холбоотой хэрэгжилтийг | 90% | 90 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | илгээсэн.<br>Хавсралт: 5 файл | | |
| 4.2. | Яамны үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, төрийн захиргааны байгууллага, харьяа байгууллагын болон салбарын хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх, манлайллаар хангах, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг, үйлчилгээ үзүүлнэ. | - | - | - | - | | Яамны үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, салбарын хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлж ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлж дэмжлэг, үзүүлж ажиллалаа. | 100% | 90 % |
| 4.2.1 | Яамны хөдөлмөрийн дотоод | 2025 оны батлагдсан | 1. Дотоод журмын хэрэгжилтий | - | Байгууллагын хөдөлмөрийн | Байгууллагын хөдөлмөрийн | Боловсролын яамны "Хөдөлмөрийн дотоод журам"-ын хэрэгжилтийг хангах хүрээнд | 90% | 90 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | журмын хэрэгжилтийг хангаж ажиллах; | төсвийн хүрээнд | н биелэлтийн хувь 2. Гаргасан шийдвэрийн тоо 3. Олгосон санхүүжилтын дүн | | дотоод журмын хэрэгжилтийг ханган ажилласан байна. | дотоод журмын хэрэгжилтийг ханган ажилласан байна. | дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. 1.Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны "Эцэг эхийн зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай" А/89 дүгээр тушаалыг батлуулав. 2.Албан хаагчдыг компьютер, техник, хэрэгслээр хангах, өрөө, тасалгааны засвар, үйлчилгээ, тохижилтод анхаарч холбогдох мэргэжилтнүүдтэй хамтарч, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллав. ТНБДаргын 2025 оны Зардал батлах тухай А/27, А/88 дугаар тушаалаар 4 өрөөний засварыг хийж гүйцэтгүүлэв. 3.Албан хаагчдын албан хэрэгцээнд ашиглаглаж байсан тавилга шинэчлэх ажлыг Хөрөнгө оруулалтын хэлтэстэй хамтран зохион байгуулав. 85 албан хаагчийн тавилга шинэчилэх шаардлагатай байгаагаас эхний ээлжинд санхүүгийн гүйцэтгэлээр 31 албан хаагчдын тавилгыг шинэчлэв. 4.Мэдээллийн цагийн төлөвлөгөө батлуулан, хэрэгжилтийг зохион байгууллаа. 2025 оны эхний хагас жилд 10 удаагийн мэдээллийн цагийг хийв. 5.Албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд чиг үүргийн дагуу тухай бүр дэмжлэг үзүүлж ажиллав. 6.Нэгжийн дарга нар болон албан хаагчдийн түр эзгүйд бие биеэ орлон ажиллах хуваарийг нэгжүүдээс санал авч батлуулав. | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 7.Засгийн газрын 2024 оны "Хуулийн биелэлтийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 164 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Боловсролын яамны албан хаагчдын ажлын өдөр зайнаас ажиллах хуваарийг нэгтгэн танилцуулав. 8. Албан хаагчдын цаг бүртгэлийн төхөөрөмжийг шинэчлэх ажлыг холбогдох мэргэжилтэнтэй хамтран хийж гүйцэтгэв. 9.Хөдөлмөрийн дотоод журмыг үндэслэн буцалтгүй тусламж олгох тухай 1 тушаал 10. Цалинтай цалингүй чөлөө олгох тухай 6 тушаал 11. Мөнгөн тусламж олгох тухай 2 тушаал 12.Нөхөн төлбөр олгох тухай 2 тушаал 13.Ажлын хариуцлаг алдсан тухай 2 Албан даалгаварыг тус тус боловсруулж албажуулсан.<br>Хавсралт: 14 файл | | |
| 4.2.2 | Хүний нөөцийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллах; | - | Батлагдсан бодлогын баримт бичгийн дагуу зохион байгуулсан арга хэмжээний тоо | Бодлогын баримт бичгийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын тоо | Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажилласан байна. | Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажилласан байна. | 1.Хүний нөөцийг сонгон бүрдүүлэх, албан тушаалд шатлан дэвшүүлэх, шилжүүлэн сэлгэн ажиллуулах ажлын хүрээнд Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлд заасны дагуу яамны 2 албан хаагч ХББОСЯам болон ХГБХХЕГ-т ажиллахаар 2 жилийн хугацаатай сэлгэн ажиллах гэрээ байгуулан ажиллаж байгаа бол 2 албан хаагч СЯ болон НБГ-аас | 90% | 90 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тус яаманд шилжин ажиллаж байна. Төрийн албаны тухай хуулийн 3.1.3-т заасны дагуу яамны 3 албан хаагч тухайн албан тушаалд тусгай шалгалт өгч тэнцэн мерит зарчмаар шатлан дэвшсэн болно. Мөн хуулийн 27.1.3-т заасны дагуу тухайн албан тушаалын сул орон тоонд тусгай шалгалт өгч хамгийн өндөр оноогоор тэнцсэн 8 иргэнийг ТНБД-ын тушаалаар томилоод байна. 2. Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр , Ёс зүйн дэд хорооны даргын баталсан “Боловсролын яамны ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Ёс зүйн дэд хорооны харилцан туршлага солилцох, боломжийг бүрдүүлэх, байгууллагын соёл, төрийн албан хаагчийн ёс зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор Аймаг, нийслэлийн Боловсролын газрын болон яамны харьяа байгууллага дундын цахим бүлгийг үүсгэв.Мөн Улаанбаатар хот болон хөдөө орон нутаг дахь Боловсролын яамны харьяа байгууллагын ёс зүйн дэд хорооны гишүүд, томилох эрх бүхий албан тушаалтнуудад “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, ёс зүйн дэд хороог чадавхижуулах сургалт”-ыг | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | цахимаар, Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн сурагчид, Их дээд сургуулийн төгсөх ангийн оюутуудад “Ёс зүйн манлайллыг төлөвшүүлэх, шударга ёс ил тод байдлыг эрхэмлэх, хариуцлагтай иргэн байх сургалт”-ыг зохион байгуулах тухай хүсэлтийг ЁЗХ-нд хүргүүлж, 06 дугаар сард зохион байгуулагдана. 3.Төрийн мэдээллийн аюулгүй байдал, нууцлалын шаардлагад нийцсэн хүний нөөцийн удирдлагын цахим системийг тасралтгүй баяжуулан ажиллаж, Яамны бүх албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг цахим системд бүртгүүлэн ажиллав. Хавсралт: 1 файл | | |
| 4.2.3 | Яамны архивын үйл ажиллагааг зохион байгуулж, мэдээлэл лавлагаагаар хангах, Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх, үнэлж дүгнүүлэх; | - | Улсын үзлэгт бэлтгэж хэрэгжүүлсэн ажлын тоо, улсын үзлэгийн дүн, архивын нэгж үүсгэсэн хадгаламжийн нэгжийн тоо | Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар батлагдсан "Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт", архив үүсгэсэн нэгж баримтууд | Бичиг баримтыг стандартын дагуу бүрэн гүйцэт бүртгэн хадгаламжийн нэгж үүсгэсэн байна. Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх, үнэлж дүгнүүлсэн | Бичиг баримтыг стандартын дагуу бүрэн гүйцэт бүртгэн хадгаламжийн нэгж үүсгэсэн байна. Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх, үнэлж дүгнүүлсэн | Боловсролын яамны 2024 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг 2025 оны 03 дугаар сард Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж хуваарийн дагуу албан хаагчдаас бичиг баримтыг хүлээн авсан. Цагдаагийн ерөнхий газраас 2023 онд Боловсролын зээлийн сан, гадаад дотоод тэтгэлэгтэй холбоотой 344 архивын нэгж авсан байсныг 2025 оны 5-р сард буцаан авсан. 2024 оны Боловёролын сайдын А тушаал 6 боть, Б тушаал 1 боть баримтыг үдэж хавтаслан PDF болгон цахимжуулсан. Иргэн, | 70% | 70 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байна. | байна. | байгууллага, албан хаагчдын хүсэлтийн 189 лавлагаанд хуулбар үнэн тэмдэг дарж хүлээлгэн өгсөн. Шинжлэх ухааны асуудал Эдийн засаг, хөгжлийн яаманд шилжсэнтэй холбоотойгоор 200 гаруй архивын нэгжийг тус яаманд хүлээлгэн өгсөн. Үндэсний аудитын газраас явуулсан хяналт шалгалтын хүрээнд холбогдох баримтуудыг хуулбар үнэн дарж хүлээлгэн өгсөн.<br>Хавсралт: 1 файл | | |
| 4.2.4 | Боловсролын яамны Төсвийн ерөнхийлөн захирагч-шууд захирагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, яамны нэгж болон албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулах, тайлагнах, урамшуулах ажлыг зохион байгуулах; | батлагдсан төсвийн хүрээнд | Боловсролын яамны албан хаагчдын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь, урамшууллын хувь хэмжээ, тушаал шийдвэрийн тоо | Боловсролын яамны албан хаагчдын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлтийн хувь, тайлан, үнэлгээ, шийдвэр | Яамны Төсвийн ерөнхийлөн захирагч-шууд захирагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулах ажлыг зохион байгуулсан байна. Яамны албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг хангуулах, үнэлж дүгнэн | Яамны Төсвийн ерөнхийлөн захирагч-шууд захирагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулах ажлыг зохион байгуулсан байна. Яамны албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг хангуулах, үнэлж дүгнэн | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 51 зорилт, 141 арга хэмжээг цахим системд оруулж батлуулсан. Нэгжийн төлөвлөгөө, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, нэгтгэх, батлуулахад дэмжлэг болж ажилласан. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хавсралт 311 буюу нийт 30 зорилт, 154 арга хэмжээний хүрээнд тайланг цахим системд оруулж, ХШҮДАГ-т шилжүүлсэн. /Төлөвлөгөө, тайланг https://plan.igovernment.mn/planorgan/ Боловсролын яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион байгуулалтаар хангаН ажилласан. БНБТГ-аас ирүүлсэн Төлөвлөгөөний төсөлд | 90% | 90 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хариуцлага тооцох, урамшуулах шийдвэр гарсан байна. | хариуцлага тооцох, урамшуулах шийдвэр гарсан байна. | нэжүүдээс ирсэн саналыг тусган 51 зорилт 142 арга хэмжээтэй боловруулан цахим системд оруулж ТНБД-р хянуулан батлуулсан. МУ-н Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг нэгжүүдэд хүргүүлэн газар, хэлтсийн төлөвлөгөөндөө тусган ажиллах талаар чиглэл хүргүүлсэн. Боловсролын яамны нэгжийн болон албан хаагчдын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийг үнэлэх үнэлгээний багийг ТНБД-ын А/131 тоот тушаалаар батлуулсан. Тус тушаалын хэрэгжилтийг хангаж, хурлын протокол хөтлөх, урамшууллын шийдвэрийг гарган ажиллахаар төлөвлөж байна.<br>Хавсралт: 2 файл | | |
| 4.2.5 | Боловсролын яамны Төсвийн ерөнхийлөн захирагч-харьяа байгууллагын төсвийн шууд захирагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, үр дүнгийн | - | Харьяа байгууллагын удирдлагатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөө, үр дүнгийн гэрээний тоо, хэрэгжилтийн хувь, тушаал шийдвэрийн тоо | 2024 оны төлөвлөгөө, гэрээ, тайлан, үнэлгээ, шийдвэр | Үр дүнгийн гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталгаажуулж, үнэлж дүгнэн хариуцлага тооцох, урамшуулах шийдвэр гарсан байна. | Үр дүнгийн гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталгаажуулж, үнэлж дүгнэн хариуцлага тооцох, урамшуулах шийдвэр гарсан байна. | Аймаг, нийслэлийн Боловсролын газар, яамны харьяа байгууллагуудын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Боловсролын нэгдсэн бодлого төлөвлөлтийн газраас санал авч, харьяа байгууллагын төлөвлөгөөг Боловсролын нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга П.Оюунаагаар хянуулах ажлыг зохион байгуулсан. Зарим байгууллагын төлөвлөгөөнд 2-3 удаагийн засвар оруулж хянуулсан. | 90% | 90 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | гэрээг батлуулах, тайланг үнэлж, дүгнэх ажлыг зохион байгуулах; | | | | | | Боловсролын сайдаас гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталгаажуулсны дараа салбарын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд байгууллагуудын төлөвлөгөөг баталгаажуулсан. Байгууллагын төлөвлөгөөг үнэлэх үнэлгээний багийг Боловсролын сайдын тушаалаар батлуулахаар тушаалын төслийг боловсруулж цахим системд оруулсан.<br>Хавсралт: 2 файл | | |
| 4.2.6 | Боловсролын яамны Төсвийн ерөнхийлөн захирагч-шууд захирагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг нэгтгэн Хяналт-шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлэх; | - | Боловсролын яам болон төрийн жинхэнэ албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн хувь | Боловсролын яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, тайлан | Яамны Төсвийн ерөнхийлөн захирагч-шууд захирагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас жилийн тайланг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн байна. | Яамны Төсвийн ерөнхийлөн захирагч-шууд захирагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эилийн эцсийн тайланг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн байна. | Яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг хуулийн хугацаанд : 1. Бодлогын баримт бичигт тусгагдсан 6 зорилт, 40 арга хэмжээ 3. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргинй хэрэгжүүлэх 17 зорилт, 91 арга хэмжээ 3. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх 7 зорилт 23 арга хэмжээ 4. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хавсралт 311 буюу нийт 30 зорилт, 154 арга хэмжээний хүрээнд тайланг цахим системд оруулж, ХШҮДАГ-т шилжүүлсэн. /Төлөвлөгөө, тайланг https://plan.igovernment.mn/planorgan/ . Арга хэмжээний нэгжийн үнэлгээ 115-100%, 33-90%, 4-70%, 2-50% үнэлэгдсэн байна нийт дундаж 96,43%-тай байна. 2024 оны жилийн эцсийн албан | 90% | 90 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг үнэлэх үнэлгээний багт нарийн бичгийн даргаар ажилласан бөгөөд холбогдох үнэлгээний хуудсыг албан хаагч бүрээр баталгаажуулан архивд шилжүүлсэн. Байгууллагын 2024 оны хөтлөх нэрийн жагсаалтын дагуу Яамны үйл ажиллагааны жилийн ажлын төлөвлөгөө болон тайлангийн баримт бичгийг архивын нэгж болгон архивд шилжүүллээ.<br>Хавсралт: 1 файл | | |
| 4.2.7 | Төрийн албаны зөвлөлийн Боловсролын яамны дэргэдэх салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг хангаж, тайланг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх; | - | Төлөвлөгөөний биелэлтийн хувь | Төрийн албаны зөвлөлийн Боловсролын яамны дэргэдэх салбар зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний тайлан | Төрийн албаны зөвлөлийн Боловсролын яамны дэргэдэх салбар зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хагас жилийн тайланг Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн байна. | Төрийн албаны зөвлөлийн Боловсролын яамны дэргэдэх салбар зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний жилийн эцсийн тайланг Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн байна. | Салбар зөвлөлийн даргын 2025 оны 01 дүгээр тогтоолоор Салбар зөвлөлийн ажиллах 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллав. Салбар зөвлөл 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 4 удаа хуралдан яам харьяа байгууллагын албан хаагчдын зэрэг дэв, яам, агентлагийн сул орон тооны тусгай болон харьяа байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтын дүн, яамны зарим албан хаагчдын төрийн жинхэнэ албан хаагчийн Тангараг өргөх ёслолын үйл ажиллагаа, зэрэг асуудлуудыг хэлэлцэн 58 тогтоол, 21 албан бичиг батлан гаргасан байна. | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ТАЗ-ийн яамны дэргэдэх салбар зөвлөл нь Төрийн албаны тухай хууль, тогтоомж, Салбар зөвлөлийн ажиллах журмын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан. Үүнд: 1. Салбар зөвлөлийн дарга 2024.02.10-ны өдрийн “Албан хаагчдад зэрэг дэв ахиулан болон шинээр олгох тухай” 14, 15 дугаар тогтоолыг баталж, Боловсролын сайдын 2025.02.14-ний өдрийн Б/06, Б/07 дугаар тушаалаар нийт 15 албан хаагчид зэрэг дэв шинээр олгож 14 албан хаагчдын зэрэг дэвийг ахиулсан болно. 2. Төрийн захиргааны албан тушаалд анх удаа, жинхлэн томилогдож, төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх эрх нь үүссэн Боловсролын яамны 3 албан хаагч Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөв. "Шинэтгэлээр түүчээлсэн салбар зөвлөл" аяны хүрээнд ТНБД-ын 2025 оны А/53 дугаар тушаалыг батлуулан хэрэгжилтийг хангаn ажиллав. Үүнд: 1. Төрийн албаны зөвлөлийн 30 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан ТАЗ-с эрхлэн гаргах номонд БЯ-ны Салбар зөвлөлийн түүхэн танилцуулгыг бэлтгэн хүргүүллээ. 2.Яам болон харьяа байгууллага, аймаг нийслэлийн Боловсролын газрын хүний нөөцийн чиглэлээр ажиллаж буй албан хаагчдыг нэгтгэн EDU-HR | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | клуб байгуулав. 3.Төрийн албанд олон жил үр бүтээлтэй ажилласан ахмад ажилтнуудын хуримтлуулсан мэдлэг, ур чадвар, туршлага, үнэт зөвлөгөөг залуу үеийн төрийн албан хаагчдад түгээх, байгууллагын соёл, залгамж холбоог бэхжүүлэх зорилгоор “Ахмад ажилтны зөвлөх үйлчилгээ” арга хэмжээг 6 дугаар сард багтаан зохион байгуулна. Хавсралт: 4 файл | | |
| 4.2.8 | Яамны авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг хханган тайлагнах, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан | - | Төлөвлөгөөний биелэлтийн хувь, ХАСУМ, ХАСХОМ гаргасан нийтийн албан тушаалтны тоо | 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, 2024 оны ХАСХОМ-ийн тайлан | Боловсролын яамны 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан байна. ХАСУМ, ХАСХОМ-ийг хугацаанд нь бүрэн гаргуулж баталгаажуулсан байна | Боловсролын яамны 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан байна. ХАСУМ, ХАСХОМ-ийг хугацаанд нь бүрэн гаргуулж баталгаажуулсан байна | Боловсролын яамны 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг Авлигын эсрэг үндэсний сүлжээний цахим системээр тайлагнаж, Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 2/22 дугаартай албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан Боловсролын яамны хариуцах арга хэмжээний хэрэгжилтийг Авлигын эсрэг үндэсний сүлжээний цахим системээр тайлагнаж, Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 2/380 дугаартай албан бичгээр хэрэгжилтийн тайланг Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. Төрийн нарийн бичгийн даргын | 100% | 90 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сэргийлэх тухай хуульд заасан холбогдох заалтын хэрэгжилтийг ханган ажиллах; | | | | | | 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн "Төлөвлөгөө батлах тухай" А/65 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар Боловсролын яамны 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг, 2 дугаар хавсралтаар Боловсролын яамны шударга байдлын үнэлгээг сайжруулах 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлуулсан. Авлигын эсрэг төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд албан тушаалд шинээр томилогдох албан хаагчдын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн эрхийг нээж баталгаажуулан томилох эрх бүхий албан тушаалтны албан бичгээр авлигатай тэмцэх газарт хүргүүлж ажилласан. Хавсралт: 3 файл | | |
| 4.2.9 | Боловсролын яамны үйл ажиллагааны сарын тайланг нэгтгэн сар бүрийн 5-ны | - | Байгууллагын үйл ажиллагааны сарын тайлангийн биелэлтийн хувь | 2024 оны байгууллагын үйл ажиллагааны сар бүрийн тайлангийн | Боловсролын яамны үйл ажиллагааны сарын тайланг нэгтгэн боловсруулж | Боловсролын яамны үйл ажиллагааны сарын тайланг нэгтгэн боловсруулж | Яамны үйл ажиллагааны 2024 оны 12 дугаар сарын тайлан 6 чиглэлээр 33 арга хэмжээ, 2025 оны 01дүгээр сарын тайлан 6 чиглэлээр 35 арга хэмжээ, 02 дугаар сарын тайлан 6 чиглэлээр 35 арга хэмжээ, 03 | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | өдрийн дотор ЗГХЭГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд оруулан баталгаажуулах; | | | үнэлгээ | , ЗГХЭГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд оруулан баталгаажуулсан байна. | , ЗГХЭГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд оруулан баталгаажуулсан байна. | дугаар сарын тайлан 6 чиглэлээр 48 арга хэмжээ, 04 дүгээр сарын тайлан 6 чиглэлээр 49 арга хэмжээ, 05 дугаар сарын тайлан 6 чиглэлээр 50 арга хэмжээний тайланг холбогдох нэгжүүдээс авч нэгтгэн хуулийн хугацаанд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлж, үнэлгээний мэдээллийн цахим санд оруулан баталгаажуулсан болно. /https://new.unelgee.gov.mn/monthreport/ /https://moe.gov.mn/posts?user_id=2649# хаягнаас ил тод мэдээллийн тайлан хэсэгт сар бүр яамны сарын товч мэдээ орж байгаа/ Мөн цахим сүлжээ, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэнд Боловсролын яамны пэйж хуудас буюу ил тод мэдээллийн тайлан мэдээ цэсэд байршуулахаар хүргүүлсэн болно. Сайдын шуурхайд сайд, ТНБД, холбогдох газар, хэлтэс, харъяа байгууллагын удирдлагуудад, 25 нэгжийн 14 хоногийн мэдээг 5 удаа гаргаж мэдээлэл хэвлэн өгч, танилцуулж ажилласан байна. Мөн ТЗУГ-ын шуурхай хурал 2025 оны хагас жилийн байдлаар 5 удаа хуралдсан ба өгөгдсөн үүрэг даалгавар, хурлын тэмдэглэлийг хөтөлж баталгаажуулж, цахим системд оруулсан. БЯ-ны дэргэдэх | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Салбар зөвлөлийн даргын 2025 оны 27, 31 дүгээр тогтоолоор баталсан шалгалтын комиссд гишүүн, нарийн бичгийн даргаар ажиллаж сул орон тоо нөхөх тусгай шалгалтыг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулж ажиллалаа. Архангай аймагт 2 удаагийн томилолтоор ажилласан ба Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд Бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдааны бэлтгэл ажил, сургуулийн өмнөх боловсрол болон бага боловсролын хөтөлбөрийн шинэчлэлийн туршилтын явц, Хангайн бүсийн эрүүл мэндийн үйлчилгээ сувилахуйн сургууль, эрдэм шинжилгээний цогцолбор барилгын ажлын явцтай танилцах ажлаар ажлаад ирсэн. Төлөвлөгөөнд туссан "Төрийн албан хаагчийн төрийн албанд ажиллахын давуу талыг илэрхийлсэн контент" бэлтгэх ажлыг хариуцан ажиллаж дуусгасан.<br>Хавсралт: 12 файл | | |
| 4.2.10 | Яамны албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, | - | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь | 2024 оны өргөдөл, гомдлын шийдвэрлэлт | Яам болон харьяа байгууллагад ирүүлсэн иргэдийн өргөдөл, гомдлын | Яам болон харьяа байгууллагад ирүүлсэн иргэдийн өргөдөл, гомдлын | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг Архивын ерөнхий газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/91 тоот тушаалаар шинэчлэн боловсруулан ажиллаж байна. Архив, албан хэрэг хөтлөлтийн | 70% | 70 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавих, тайлан мэдээг тогтоосон хугацаанд гаргаж ЗГХЭГ-т хүргүүлэх; | | | | шийдвэрлэлтийн тайлан мэдээг тогтоосон хугацаанд ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. | шийдвэрлэлтийн тайлан мэдээг тогтоосон хугацаанд ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. | үйл ажиллагааг холбогдох хууль, журам, стандартын дагуу зохион байгуулан ажиллаж байна. Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөс 352 иргэний өргөдөл, гомдлыг хуваарилж, шилжүүлсэн байна. Үүнээс 310 өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, 42 өргөдөл, гомдол хугацаандаа судлагдаж байна. 11-11 төвтэй тогтмол хамтран ажиллаж, тус төвөөс илгээсэн иргэдийг биечлэн хүлээн авч уулзаж, зөвлөгөө, мэдээллээр ханган ажилласан. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тогтмол хяналт тавьж, холбогдох мэдээ, мэдээллийг яамны дотоод сүлжээгээр нийт албан хаагчдад тухай бүр мэдээлж ажиллалаа. Мөн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн 1 дүгээр улирлын тайланг 4 дүгээр сарын 9-ний өдрийн 2/1393 дугаар албан бичгээр Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлж ажилласан.<br>Хавсралт: 1 файл | | |
| 4.2.11 | Сайд, Төрийн нарийн бичгийн даргын баталсан тушаал, шийдвэрийн хэрэгжилт, | - | баталсан тушаалын тоо, биелэлтийн хувь | 2024 онд баталсан тушаалын биелэлт | Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хяналт | Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хяналт | 2025 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр хүртэл нийт 131 Төрийн нарийн бичгийн даргын тушаал гарсан . Үүнээс 2025 оны 03 сарын 21 хүртэлх нийт 60 тушаалын хэрэгжилтийг холбогдох албан хаагчдаас авч, хяналт шинжилгээ үнэлгээ | 70% | 70 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Үндэсний зөвлөлүүдээс гаргасан шийдвэрийг холбогдох асуудал хариуцсан албан хаагчдад хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах, биелэлтийн тайланг нэгтгэж удирдлагад танилцуулах; | | | | шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим системээр тайлагнасан байна. Үндэсний зөвлөлүүдээс гаргасан шийдвэрийн биелэлтийг нэгтгэж тайлагнасан байна. | шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим системээр тайлагнасан байна. Үндэсний зөвлөлүүдээс гаргасан шийдвэрийн биелэлтийг нэгтгэж тайлагнасан байна. | хийлгэхээр ХШҮДАГ-т хүлээлгэн өгсөн. Түүнээс хойш гарсан тушаал шийдвэрүүдийг нэгтгэн, тушаал гаргасан албан хаагчдаас хэрэгжилийг авахад бэлэн болгосон. Төрийн нарийн бичгийн дарга тушаал батлагдаж албажмагц Microsof 365 системд оруулан ажиллаж байна.<br>Хавсралт: 1 файл | | |
| 4.2.12 | Төрийн албаны зөвлөлийн Боловсролын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, Яам болон харьяа байгууллагын удирдах, гүйцэтгэх албан тушаалтны сул орон тооны | - | Сул ажлын байрны тоо, зохион байгуулсан сонгон шалгаруулалтын тоо, үр дүн | 2024 онд зохион байгуулсан сонгон шалгаруулалтын тоо | Яам, харьяа байгууллага болон аймгийн Боловсролын газрын даргын сул орон тооны судалгаа гаргаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан байна. Түр орлон гүйцэтгэгчийн тоо тодорхой хувиар буурсан | Яам, харьяа байгууллага болон аймгийн Боловсролын газрын даргын сул орон тооны судалгаа гаргаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан байна. Түр орлон гүйцэтгэгчийн тоо тодорхой хувиар буурсан | 1. Булган, Өмнөговь, Баянхонгор, Сэлэнгэ аймгийн боловсролын газрын даргын албан тушаалын сул орон тоонд тусгай шалгалтыг 2025.01.08-01.21-ний өдрүүдэд нээлттэй зарлаж Салбар зөвлөлийн даргын 13 дугаар тогтоолоор байгуулагдсан шалгалтын комисс 2025.01.30-ны өдөр Өмнөговь, Булган, Сэлэнгэ аймгийн боловсролын газрын даргын албан тушаалын сул орон тооны тусгай шалгалтыг амжилттай зохион байгуулж Салбар зөвлөлийн даргын 2025 оны 17, 18 дугаар тогтоолоор Булган, Сэлэнгэ аймгийн БГ-ын даргыг томилохоор нэр дэвшүүлэв. 2. Төрийн албаны зөвлөлийн Боловсролын яамны | 100% | 90 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | судалгааг гаргах, Төрийн албаны зөвлөлд захиалга хүргүүлэх, тусгай шалгалт болон сонгон шалгаруулалтыг зохион байгуулах | | | | байна. | байна. | дэргэдэх Салбар зөвлөлийн даргын 2025 оны 19,20,21 дүгээр тогтоолоор байгуулагдсан шалгалтын комисс БЯ-ны ахлах түшмэлийн 3, дэс түшмэлийн 1, НТСТ-ийн захирлын албан тушаалын сул орон тоонд тусгай шалгалтыг 2025.03.19-21-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулав. Шалгалтын комиссын тайланг Салбар зөвлөл 2025.03.27-ны өдөр хэлэлцэж яамны холбогдох албан тушаалын сул орон тоонд хамгийн өндөр оноо авч тэнцсэн 4 иргэн, Говьсүмбэр аймгийн НТСТ-ийн захирлын сонгон шалгаруулалтад тэнцсэн 1 иргэнийг Салбар зөвлөлийн даргын 22,23,24,25,26 дугаар тогтоолоор тухайн албан тушаалд нэр дэвшүүлэв. 3. Төрийн албаны зөвлөлийн Боловсролын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн даргын 2025 оны 27, 28, 29, 30, 31 дүгээр тогтоолоор байгуулагдсан шалгалтын комисс Боловсролын яамны дэс түшмэлийн 2, Баянхонгор аймгийн боловсролын газрын дарга, Нийслэлийн 5 дүүргийн боловсролын хэлтсийн дарга, Нийслэлийн боловсролын газрын дэс түшмэлийн 5, 9 дүүргийн Боловсролын хэлтсийн дэс түшмэлийн 38 албан тушаалын сул орон тоонд тусгай шалгалтыг 2025.04.23-25, | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2025.04.28-29-ний өдрүүдэд тус тус амжилттай зохион байгуулав. Шалгалтын комиссын тайланг Салбар зөвлөл 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр хэлэлцэж Салбар зөвлөлийн даргын 32-69 дүгээр тогтоолоор тухайн албан тушаалд нэр дэвшүүлэв. Хавсралт: 1 файл | | |
| 4.2.13 | Боловсролын яамны албан хаагчдын сургалтын болон нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах; | - | Сургалтын тоо, төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 2024 оны сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Боловсролын яамны албан хаагчдын сургалтын болон нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажилласан байна. | Боловсролын яамны албан хаагчдын сургалтын болон нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажилласан байна. | Монгол Улсын Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь заалт, Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2025 оны эхний хагас жилийн байдлаар дараах ажлыг хэрэгжүүлэн шийдвэрлүүлж ажилласан. Үүнд: 1. Буцалтгүй тусламж, дэмжлэг, нөхөн олговор ажлын хүрээнд Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/93 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын дагуу 2 албан хаагчид 1 сая төгрөгийн 1 албан хаагчид 1 сарын цалинтай тэнцэх мөнгөн тусламжийг ТНБД-ын тушаалаар шийдвэрлэн олгосон. 2. 7 албан хаагчид эрүүл мэндийн үзлэг оношлогоо хийлгэх, баган насны хүүхэд болон гэрийн бүлийн гишүүнийг асрахад нь 7-14 хоногийн цалинтай болон цалингүй чөлөө олгож ТНБД-ын | 90% | 90 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тушаалаар шийдвэрлэсэн. 3. 2 албан хаагчид Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам"-ын 8.5 дахь заалтын дагуу 3 сарын цалинтай тэнцэх хэмжээн нөхөн олговорыг тус тус олгож шийдвэрлэсэн. 4.Яамны албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх зорилгоор өглөө бүр мэргэжлийн багшийн удирдлага дор иогийн хичээлд амжилттай хамрагдаж байна. 5. ТЗУГ-аас албан хаагчдын ажиллах орчны нөхцлийг сайжруулах хүрээнд бичгийн ширээ, шүүгээ, шкаф зэрэг тавилгыг шинэчилж, тус бүрт нь тохирсон ажлын нөхцөлийг бүрдүүллээ. Хавсралт: 2 файл | | |
| 4.2. 14 | Салбарын шагнал урамшууллын бодлого, зохицуулалтыг зохион байгуулах, сан бүрдэлтэд хяналт тавих; | Батлагдсан төсвийн хүрээнд | Шагналын сангийн мэдээллийн хувь, хэмжээ, олгосон шагналын тоо, тушаал шийдвэрийн тоо | 2024 онд шагнагдсан албан хаагчдын тоо | Шагнагдсан албан хаагчдын мэдээллийг шагналын сангийн мэдээлэлд оруулсан байна. Холбогдох тушаал шийдвэрүүд гарсан | Шагнагдсан албан хаагчдын мэдээллийг шагналын сангийн мэдээлэлд оруулсан байна. Холбогдох тушаал шийдвэрүүд гарсан | Боловсролын сайдын 2024 оны Журам шинэчлэн батлах тухай А/28 дугаар тушаалаар батлагдсан "Боловсролын салбарын албан хаагчид шагнал олгох журам"-ын дагуу шагналыг шийдвэрлүүлэн, хүргүүлэх ажлыг зохион байгууллаа. Боловсролын сайдын 2025 оны А/170 дугаар тушаалаар 115 Боловсролын тэргүүний ажилтан, 98 Боловсролын жуух бичиг, Боловсролын сайдын | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байна. | байна. | 2025 оны А/278 дугаар тушаалаар 227 Боловсролын тэргүүний ажилтан, 253 Боловсролын жуух бичиг, 83 Үндэсний бичиг соёлыг дэлгэрүүлэгч тус тус олгосон байна. Шагнагдсан албан хаагчдын мэдээллийн журмын дагуу Боловсролын ерөнхий газарт хүргүүлэх, шалгах, нэгтгэх ажлыг гүйцэтгэв. | | |
| 4.2.15 | Яамны албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах | - | Зохион байгуулсан, хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо Судалгаанд хамрагдсан албан хаагчийн тоо, саналын тоо | 2024 онд хийсэн судалгааны үр дүн | Яамны өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй хангаж, албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгаа авч холбогдох арга хэмжээг зохион байгуулсан байна. | Яамны өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй хангаж, албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгаа авч холбогдох арга хэмжээг зохион байгуулсан байна. | Албан хаагчдыг албан үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах мэдээ, мэдээллээр тухай бүр хангаж ажилласан. | 90% | 90 % |
| 4.2.16 | Албан хэрэг хөтлөлт, бичиг солилцооны үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж, хэвийн найдвартай | - | Цахим удирдлагын системийн ашиглалтын хувь | 2024 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа | Албан бичиг төлөвлөлт, тайлагналт үе шаттайгаар цахимжсан байна. Удирдлага, холбогдох албан хаагчид | Албан бичиг төлөвлөлт, тайлагналт үе шаттайгаар цахимжсан байна. Удирдлага, холбогдох албан хаагчид | 2025 оны хагас жилийн байдлаар 4228 албан бичгээс 2859 албан бичиг шийдвэрлэгдэж , 1369 албан бичиг шийдвэрлэгдээгүй хугацаандаа судлагдаж байна. Үүнд: Удирдах ажилтнууд (30), Боловсролын нэгдсэн бодлого төлөвлөлтийн газар (144), Дээд боловсролын газар (524), Мэргэжлийн болон техникийн | 100% | 90 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааг хангах, баримт бичгийн цахим санг тасралтгүй нэмэгдүүлэх; | | | | албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд цахим гарын үсгийг бүрэн ашиглаж хэвшсэн байна. | албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд цахим гарын үсгийг бүрэн ашиглаж хэвшсэн байна. | боловсролын газар (208), Ерөнхий боловсролын газар (185), Цахим боловсролын газар (96), Гадаад хамтын ажиллагааны газар (495), Санхүү, хөрөнгө оруулалтын газар (1380), Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар (65), Салбарын хяналтын газар (93), Төрийн захиргааны удирдлагын газар (714). 1047 өргөдөл, гомдол ирснээс 798 өргөдөл гомдол шийдвэрлэгдэж, 249 өргөдөл, гомдол хугацаандаа судлагдаж байна. 2025 оны хагас жилийн байдлаар 1000 гаруй иргэн биелэн ирж хүсэлт гаргасныг тухай бүр мэдээ мэдээллээр хангаан ажилласан. Боловсролын яамны 2025 оны эхний хагас жилийн хугацаанд Microsoft 365 платформд суурилсан албан бичгийн системийг байгууллагын хэрэгцээ, дотоод урсгалд нийцүүлэн хөгжүүлж, хэрэглээнд бүрэн нэвтрүүлэн ажиллав. Систем хөгжүүлэлтийн хүрээнд Microsoft 365-ийн SharePoint, Power Apps, Power Automate зэрэг үндсэн хэрэгслүүдийг ашиглаж, албан бичиг хүлээн авах, бүртгэх, боловсруулж шийдвэрлэх, тушаал шийдвэр үүсгэх бүх үйл явцыг цахим хэлбэрт бүрэн шилжүүлсэн. Системийн үндсэн урсгал, хэрэглэгчийн хандалт, эрхийн түвшин, баталгаажуулалтын | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | механизм, мэдээллийн сангийн бүтцийг боловсруулан хэрэгжүүлсэн бөгөөд нийт хэрэглэгчдийг хамруулсан 3 удаагийн сургалт, чиглэл өгөх уулзалт зохион байгуулсан. Хөгжүүлэлтийн үр дүнд тус хагас жилийн хугацаанд нийт 7900 албан бичиг хүлээн авч, тэдгээрээс 2506 бичгийг бүрэн боловсруулж, дотоод шийдвэр, хариу бичгийг гаргасан. Үүний зэрэгцээ, байгууллагын түвшинд нийт 378 тушаал, шийдвэрийг цахимаар боловсруулан баталгаажуулсан байна. Албан бичгийн урсгал бүр системд бүртгэгдэж, хариу өгөх хугацааг тооцох, хариуцсан ажилтны хяналт, хуваарилалтыг сайжруулах боломж бүрдсэн.<br>Хавсралт: 3 файл | | |
| 4.2.17 | “Мэдээллийн цаг”- зохион байгуулах төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах; | - | "Мэдээллийн цаг"-ийг зохион байгуулсан тоо, оролцсон албан хаагчдын тоо | 2024 онд зохион байгуулсан мэдээллийн тоо, оролцсон албан хаагчдын тоо, хувь | Яамны 2025 оны “Мэдээллийн цаг”-ийн төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан байна.. | Яамны 2025 оны “Мэдээллийн цаг”-ийн төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан байна.. | Яамны албан хаагчдын мэдээллийн цагийн эхний хагас жилийн төлөвлөгөө батлуулан, хэрэгжилтийг ханган зохион байгуулалтыг хийв. Нэгжүүд батлагдсан хуваарийн дагуу хамтран ажиллав. Дараах сэдвийн хүрээнд 10 удаагийн мэдээллийн цаг хийсэн байна. 1."365 программын хэрэглээний талаар" - ТЗУГ 2."Их өгөгдөлд суурилсан боловсролын бодлого, төлөвлөлт" - П.Оюунаа /Боловсхролын яамны Боловсролын нэгдсэн бодлого | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төлөвлөлтийн газрын дарга/ 3."Төрийн чадамжийг бүрдүүлэх нь" - Б.Дөлгөөн /Монголын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирал/ 4."Төрийн албан дахь ёс зүйн боловсрол, харилцаа хандлагыг ээрэгжүүлэх техник оролцоонд тулгуурласан сургалт"- Р.Лхагвадулам /Имако институтийн захирал/ 5."Боловсролын хувирган өөрчлөлт" - Ц.Дэмбэрэл /Монголын ирээдүй судлалын нийгэмлэгийн тэргүүн/ 6."Хиймэл оюун, технологийн хувьсгал" - Ц.Эрдэнэбат /Эдийн засаг хөгжлийн яамны нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга/ 7."Хувь хүн, байгууллагын кибер аюулгүй байдал" - Кибер гэмт Хэрэгтэй тэмцэх газрын Тоон ул мөр илрүүлэх хэлтсийн ахлах мөрдөгч ахлах дэслэгч З.Төрболд, Кибер гэмт Хэрэгтэй тэмцэх газрын Тоон ул мөр илрүүлэх хэлтсийн ахлах мөрдөгч ахлах дэслэгч Э.Пүрэв-Очир 8."Хөрөнгө оруулалт ба хөрөнгийн зах зээлийн тухай" - Ё.Амарбат /Стоклаб секьюритиз ҮЦК" ХХК-ийн гүйцэтгэх захирал/ 9."Ажлын байрны ёс зүй" - Д.Ерөө /Юнайтед менежмент консалтинг, захирал/ 10."Орон нутгийн хамгаалалтын тухай хууль болон Дайчилгааны тухай хуулийн хэрэгжилтийн талаар" Батлан хамгаалах яамны холбогдох албан хаагчид Албан | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хаагчдын оролцоо 90 хувь байв. Хавсралт: 11 файл | | |
| 4.2.18 | Яамны 2025 оны батлагдсан төсвийн хүрээнд төсвийн хуваарийн зохицуулалт хийх, санхүүжилтийн эрхийг хугацаанд нээлгэх, төсвийн гүйцэтгэлийг хууль журмын хүрээнд санхүүжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг хугацаанд нь гаргаж холбогдох газарт хүргүүлэх; | - | Төсвийн гүйцэтгэл | 2024 оны батлагдсан төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг хугацаанд нь гаргаж холбогдох газарт хүргүүлсэн байна. | Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг хугацаанд нь гаргаж холбогдох газарт хүргүүлсэн байна. | Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар тутмын 5-ны дотор Төрийн санд гарган өгч Сангийн яаманд нэгтгүүлсэн. Тайлант хугацаанд 6 удаа төсвийн гүйцэтгэлийн мэдээг гарган өгч, Сангийн яаманд нэгтгүүлсэн. Мөн шаардлагатай санхүүжилтийн хуваарийг өөрчлүүлэхээр Санхүүгийн хэлтэстэй байнга хамтран ажилласан. 2, 3, 4 сард батлагдсан төсвийн хуваарьт өөрчлөлт оруулж зарим цаг үеийн шаардлагатай санхүүжилтийн асуудлуудлыг шийдвэрлэж ажилласан. Бүсийн чуулган орон нутагт зохион байгуулах Засгийн газрын шийдвэр гарсантай холбогдуулан Сангийн яам Томилолт, хурал зөвлөгөөний төсвийг 4 сард нэмэгдүүлсэн. Гэвч улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан 5 сарын 31-ээр сангийн яам бүх төсөвт байгууллагуудын дансан дахь үлдэгдлийг татан төвлөрүүлж, төсвийн хуваарийг шинэчлэн баталснаар 6 сард төсөв, санхүүгийн хүндрэл үүсэх төлөвтэй байна. Төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайлан гаргахтай холбоотой ямар нэгэн гомдол саналгүй ажилласан. | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хавсралт: 1 файл | | |
| 4.2.19 | Яамны 2025 оны батлагдсан төсвийн хүрээнд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг нь хангаж, тайлагнаж ажиллах; | - | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн хувь | Яамны 2024 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө | Боловсролын яамны 2025 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан байна. | Боловсролын яамны 2025 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан байна. | Боловсролын яамны ТНБД-ын А/21 тоот тушаалаар яамны хэмжээнд худалдан авах бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөөг 2 сарын 12-ны өдөр баталсан. Төлөвлөгөөнд тусгагдсан Салбарын шагналын тэмдэг, үнэмлэх, хавтас хэвлүүлэх, Боловсролын яамны албан хаагчдын цаг бүртгэлийн төхөөрөмж суурилуулах, Боловсролын яамны авто зогсоолын орох урсгалд давхар хаалт суурилуулах 3 арга хэмжээ бүрэн хэрэгжиж дууссан. Санхүүжилтийн хувьд Салбарын шагналын тэмдэг, үнэмлэх, хавтас хэвлүүлэх арга хэмжээний 100 сая төгрөгийн зардал Сайдын багцын Хөтөлбөр, арга хэмжээний зардлаас гарч, үлдсэн 2 арга хэмжээний зардал яамны урсгал үйл ажиллагааны төсвөөс санхүүжигдсэн. Төлөвлөгөөнд тусгагдсан, хэрэгжиж дуусаагүй 2 арга хэмжээний хувьд санхүүжилтийн асуудлаас шалтгаалан түр 30-70 хувийн гүйцэтгэлтэй байна. 3-р улиралд санхүүжилтийг шийдвэрлэн тушаалын хэрэгжилтийг бүрэн хангахаар ажиллаж байна.<br>Хавсралт: 4 файл | 100% | 100 % |
| 4.2. | Яамны | Батлагдс | 1. Албан | Яамны | Яамны | Яамны | Хөдөлмөрийн дотоод журам, | 100% | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 20 | албан хаагчдын цалин хөлсийг олгох ажлыг зохион байгуулах, НДШ, ХАОАТ-ын тайланг тогтоосон хугацаанд нь тайлагнах; | ан төсвийн хүрээнд | хаагчдын цалинг батлагдсан төсвийн хүрээнд олгосон санхүүжилтийн дүн 2.НДШ, ХАОАТ-ын тайлангийн биелэлтийн хувь | албан хаагчдын цалинг 2024 онд батлагдсан төсвийн хүрээнд олгож, НДШ, ХАОАТ-ын тайланг тайлагнасан. | албан хаагчдын цалин хөлсийг тогтоосон хугацаанд олгож, НДШ, ХАОАТ-ын тайланг хугацаанд нь тайлагнаж ажилласан байна. | албан хаагчдын цалин хөлсийг тогтоосон хугацаанд олгож, НДШ, ХАОАТ-ын тайланг хугацаанд нь тайлагнаж ажилласан байна. | Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу Яамны нийт албан хаагчдын цалинг цаг бүртгэлийн тайланг үндэслэн сар бүр 2 удаа бодож олгосон. Эхний хагас жилд 8 албан хаагчийн амралтыг бодож олгосон. 1, 2-р сард 107 албан хаагч, 3 сард 104 албан хаагч, 4 сард 113 албан хаагч, 5 сард 110 албан хаагч, 6 сард 106 албан хаагчийн цалинг бодож олгосон байна. Мөн сар бүр ХХОАТ, нийгмийн даатгалын тайланг хийж холбогдох байгууллагуудад цахимаар хүргүүлсэн.<br>Хавсралт: 17 файл | | % |
| 4.2.21 | Яамны санхүүгийн хэрэгцээ, шаардлагыг бодит, үнэн зөв тодорхойлон 2026 оны төсвийн төслийг боловсруулан батлуулах, төсвийн хуваарийн саналыг хүргүүлсэн байх; | - | Боловсролын яамны санхүүгийн 2026 оны төсвийн төсөл | Яамны санхүүгийн 2025 оны жилийн төсөв | - | Боловсролын яамны 2025 оны төсвийн төсөлд санал хүргүүлж, төсөв батлагдсан байна. | Боловсролын яамны 2026 оны төсвийн төслийн саналыг газар хэлтсээс авч нэгтгэн, Санхүү хөрөнгө оруулалтын газарт хүргүүлсэн. 2025 оны батлагдсан төсвиөөс 39 хувиар нэмэгдүүлсэн. 2025 онд 6,9 тэрбумын төсөвтэй ажиллаж байгааг 9,7 болгон нэмэгдүүлж саналыг хүргүүлсэн. Эдийн засгийн өсөлт, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт зэргийг тооцоолон нэмэгдлүүдийг тусгасан. Цаг үеийн шаардлагаар Мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг 40% нэмэгдүүлсэн. Мөн 1980 онд ашиглалтанд орсон Засгийн газрын 3-р байрны өрөө тасалгаануудад засвар хийх | 90% | 90 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зайлшгүй шаардлагатай тул урсгал засварын зардалд 100 сая төгрөг төсөвлөсөн. Хавсралт: 1 файл | | |
| 4.2. 22 | Яамны үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай техник, тоног төхөөрөмж, бичиг хэрэг, хангамжийн материалын судалгааг гаргаж, холбогдох арга хэмжээг авч ажиллах, нягтлан бодох бүртгэлийг тухай бүр үнэн зөв бүртгэж, баримтын бүрдүүлбэрийн шаардлагыг хангасан байх; | батлагдсан төсвийн хүрээнд | шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалт, хэрэгжүүлсэн ажлын тоо, нягтлан бодох бүртгэлийн тоо | 2024 онд хэрэгжүүлсэн арга хэмжээ | Яамны албан хаагчдад үйл ажиллагааг нь хэвийн явуулахад шаардлагатай техник, тоног төхөөрөмж, бичиг хэрэг, хангамжийн материалаар бүрэн хангасан байна. НББ-ийг үнэн зөв бүртгэгдсэн байна | Яамны албан хаагчдад үйл ажиллагааг нь хэвийн явуулахад шаардлагатай техник, тоног төхөөрөмж, бичиг хэрэг, хангамжийн материалаар бүрэн хангасан байна. НББ-ийг үнэн зөв бүртгэгдсэн байна | Яамны үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай техник, тоног төхөөрөмж, бичиг хэрэг, хангамжийн материалаар албан хаагчдыг тухай бүр хангаж ажилласан. Албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах хүрээнд албан хаагчдын тавилгыг шинэчлэх ажлыг зохион байгуулсан. 40 албан хаагчийн тавилга, ширээ, хувцас, баримтын шүүгээг шинэчилж, ажиллах таатай нөхцөлийг хангасан. 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 20.2 сая төгрөгийн бараа, хангамжийн материал бэлтгэн, 34.4 сая төгрөгийн хангамж, бичиг хэргийн материалыг албан хаагчдад холбогдох баримтыг бүрдүүлэн тараан олгосон байна. Хангамжийн материал дээр ямар нэгэн гомдол, саналгүй ажилласан. Хавсралт: 2 файл | 100% | 100 % |
| 4.2. 23 | Яамны 2024 оны төсөв, санхүүгийн тайлан мэдээг | - | Яамны 2024 оны төсөв, санхүүгийн тайлан мэдээ, албан | 2023 оны дүгнэлт, зөрчлийн тоо | Санхүүгийн тайланг бэлтгэн, санхүүгийн аудитад | Үндэсний аудитыг газрын зөвлөмж, акт албан | Үндэсний аудитын газрын 2024 оны санхүүгийн аудитаар ӨӨРЧЛӨЛТГҮЙ буюу онц сайн үнэлэгдсэн. Өмнөх оны шалгалтаар өгсөн албан | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Үндэсний аудитын газраар дүгнүүлж ТЕЗ-ийн тайланд нэгтгүүлсэн байх, Үндэсний аудитын газраас өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хангуулж, тогтоосон хугацаанд тайлагнах; | | бичиг, шийдвэрийн тоо | | хамрагдсан байна. | шаардлагын биелэлтийг хангаж тайланг хүргүүлсэн байна | шаардлага, актыг арилгаж, зөвлөмжийг мөрдлөг болгон ажиллаж, алдаа зөрчлийг давталгүй ажилласан. Мөн Төрийн нарийн бичгийн даргын А/60 тушаалаар Боловсролын яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлт хийсэн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг хანган ажиллаж байна. Үүний үр дүнд санхүүгийн сахилга бат нийт албан хаагчдын хэмжээнд сайжирч, баримтын бүрдэл цэгцэрсэн. Хавсралт: 2 файл | | |
| 4.2.24 | Яамны хагас, бүтэн жилийн тооллогыг хийж, яамны Өмч хамгаалах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, актлах болон шилжүүлэх | - | Бүртгэл, албан бичиг, шийдвэрийн тоо | 2024 оны хагас, бүтэн жилийн тооллогын тайлан | Яамны хагас жилийн тооллогыг чанартай зохион байгуулж холбогдох санал, шийдвэр гарсан байна. | Яамны жилийн эцсийн тооллогыг чанартай зохион байгуулж холбогдох санал, шийдвэр гарсан байна. | Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 06-р сарын 02-ны "Эд хөрөнгийн тооллого хийх тухай" А/132 тоот тушаалаар тооллогын комисс байгуулагдсан. Тооллогыг 06 дугаар сарын 12-ны өдрийг хүртэл зохион байгуулж дүнг 06-р сарын 13-нд тайлагнахаар ажиллаж байна. Актлах хөрөнгийн саналыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн. Хавсралт: 1 файл | 70% | 70 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хөрөнгийн мэдээллийг нотлох баримтыг хамт гарган ТӨБЗГ-т хүргүүлэн шийдвэрлэсэн байх, шийдвэрийг үндэслэн бүртгэлийг хөтөлж ажилласан байх; | | | | | | | | |
| 4.2.25 | Сайдын болон яамны албан хэрэгцээний цаг үеийн шаардлагатай ажлыг санхүүгийн болон бусад нөөцөөр хангах ажлыг шуурхай зохион байгуулах; | - | Хэрэгжүүлсэн ажлын тоо | 2024 онд хэрэгжүүлсэн ажлын тоо | Шаардлагатай холбогдох арга хэмжээг санхүүгийн болон бусад нөөцөөр шуурхай ханган ажилласан байна. | Шаардлагатай холбогдох арга хэмжээг санхүүгийн болон бусад нөөцөөр шуурхай ханган ажилласан байна. | Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 02-р сарын 18-ны өдрийн А/29 тоот тушаалаар Боловсролын яамны албан хаагч,ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээний бэлтгэл ажлыгзохион байгуулсан. Боловсролын Сайдын 11 удаагийн хурлын бэлтгэлийг ханган ажилласан. Боловсролын яамны албан хаагчдын хүүхдүүдийн судалгааг гаргаж Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 05-р сарын 22-ны өдрийн А/118 тоот тушаалаар холбогдох зардлыг баталж, тушаалын хэрэгжилтийг ханган ажилласан. Бусад шаардлагатай арга хэмжээнүүдийг санхүүгийн нөөцөөр бүрэн хангаж ажилласан. | 100% | 100 % |
| 4.2. | Жендерийн | - | Төлөвлөгөө, | 2024 оны | 2025 оны | 2025 оны | 1.Жендэрийн эрх тэгш байдлыг | 90% | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 26 | эрх тэгш байдлыг хангах тухай, Хүний эрхий тухай хууль тогтоомжийн холбогдох заалтын хэрэгжилтийг ханган ажиллах; | | хэрэгжилтийн хувь | төлөвлөгөөний биелэлт | төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байна. | төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байна. | хангах салбар дундын стратеги төлөвлөгөөний “Охид, хөвгүүд, эмэгтэй эрэгтэй хүмүүст эрүүл, аюулгүй амьдрах, сурч боловсрох тэгш боломж бүрдүүлнэ” 1 дүгээр зорилгын хэрэгжилтийг хангах боловсролын сайдын 2024 оны А/180 дугаар тушаалаар байгуулагдсан дэд ажлын хэсгийн гишүүдийн уулзалтыг 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдөр Боловсролын яамны хурлын танхимд зохион байгууллаа. Уулзалтаар Стратеги төлөвлөгөөний 1 дүгээр зорилгын хүрээнд салбар дундын зохицуулалт /2 ба түүнээс дээш салбар яам, байгууллагууд хамтран/ бүхий 1.1.4, 1.1.11, 1.1.13, 1.2.12, 1.2.14, 1.4.4, 1.4.8, 1.5.13 зэрэг арга хэмжээний хэрэгжилтийг хамтран хэрэгжүүлэх 8 арга хэмжээний талаарх мэдээллийг танилцуулж, хэлэлцүүлж ажилласан. 2. ЖЕНДЭРИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАН ХЯНУУЛАХАД БЭЛЭН БОЛГОСОН. Холбогдох мэдээллийг хавсралтаар оруулав.<br>Хавсралт: 2 файл | | % |
| 4.2.27 | “Газар хөдлөлтийн | - | Төлөвлөгөө, хөтөлбөрийн | 2024 оны төлөвлөгөөн | Төлөвлөгөөний | Төлөвлөгөөний | 1.Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр | 90% | 90 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөл” болон "Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл"-ийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хүргүүлж ажиллах; | | хэрэгжилтийн хувь | ий биелэлт | хэрэгжилтийг хангаж тайлагнасан байна. | хэрэгжилтийг хангаж тайлагнасан байна. | тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд 2025.03.26-ны өдрийн Лхагва гарагт яамны албан хаагчдад ОБЕГ-ын хэлтсийн дарга, хурандаа Д.Сэржмядаг ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БЭЛЭН БАЙДЛАА ХАНГАХ АРГА ХЭМЖЭЭ сэдвээр сургалт хийв. 2.2025.03.27-ны өдрийн Пүрэв гарагийн 16:00 цагт Орон даяар зарлан мэдээллийн дуут дохиогоор ажиллах дадлага сургуулилтыг Онцгой байдлын ерөнхий газрын холбогдох албан тушаалтнуудтай хамтран зохион байгуулав. 3.Батлан хамгаалах сайдын 2025 оны А/80 дугаар тушаалын дагуу батлан хамгаалах хууль тогтоомж, орон нутгийн хамгаалалтын тухай хууль болон Дайчилгааны тухай хуулийн хэрэгжилтийн талаар сургалтыг тус яамны холбогдох албан хаагчиддтай хамтран яам болон харьяа байгууллагын удирдлагуудын хүрээнд зохион байгуулав. Мөн яамны 18-50 насны эрчүүдийн судалгааг авч, ирүүлсэн маягтын дагуу нэгтгэн Батлан хамгаалах яаманд хүргүүлэв. 4. Онцгой байдлын ерөнхий газраас зохион байгуулсан Гамшгаас хамгаалсан команд штабын дадлага, сургалтад 2025 оны 03 сарын 26-28-ны өдрүүдэд оролцов. 5.Боловсролын яамны | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2025 оны Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний төслийг боловсруулав. Хавсралт: 4 файл | | |
| 4.2. 28 | Боловсролын яамны төсвийн ерөнхийлөн захирагчаас аймгийн Засаг дарга нартай гэрээ байгуулах, дүгнэх ажлыг зохион байгуулах; | - | Аймгийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний тоо, хэрэгжилтийн хувь | Боловсролын яамны төсвийн ерөнхийлөн захирагчаас аймгийн Засаг дарга нартай байгуулсан 2024 оны гэрээ | Боловсролын яамны төсвийн ерөнхийлөн захирагчаас аймгийн Засаг дарга нартай гэрээ байгуулах, дүгнэх ажлыг зохион байгуулсан байна. | Боловсролын яамны төсвийн ерөнхийлөн захирагчаас аймгийн Засаг дарга нартай байгуулсан гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулсан байна. | Аймаг нийслэлийн Засаг даргатай гэрээ байгуулах төлөвлөгөө батлуулан ажилласан. Засаг даргын 2024 оны гэрээний загвар болон үнэлгээг бэлтгэн ажлын хэсэгт хүргүүлэн 2025 оны Гэрээний төслийг 21 аймаг, нийслэлийн боловсролын газрууд руу илгээж санал авах, хэвлэх, хавтаслах ажлыг гүйцэтгэсэн. 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр Төрийн ордоны 2 дугаар давхарт, “Их Эзэн Чингис хаан” танхимд зохион байгуулсан арга хэмжээнд оролцож гэрээг албажуулсан.. Хавсралт: 3 файл | 100% | 100 % |
| 4.2. 29 | Салбарын үйлдвэрчний эвлэлийн холбоод, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах хэлэлцээрийн хэрэгжилтийг хангуулах ажлыг | - | Төлөвлөгөөний биелэлтийн хувь Гэрээ хэлэлцээрийн тоо | 2024 онд байгуулсан гэрээ хэлэлцээр, төлөвлөгөө | Салбарын үйлдвэрчний эвлэлийн холбоод, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах хэлэлцээрийн хэрэгжилтийг хангуулах ажлыг | Салбарын үйлдвэрчний эвлэлийн холбоод, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах хэлэлцээрийн хэрэгжилтийг хангуулах ажлыг | "Боловсролын яам болон Монголын Боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбооны хооронд 2024-2026 онд байгуулсан хамтын хэлэлцээрт" нэмэлт хэлэлцээрийг батлуулж Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэн 2025 оны 03 дугаар марын 18-ны өдөр хэлэлцээрийг бүргүүлсэн. Нэмэлт хэлэлцээрийн барим бичгийг хэлэлцээрт оролцон ажиллах газар, нэгжийн дарга | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулах; | | | | зохион байгуулсан байна. | зохион байгуулсан байна. | нарт цахимаар хүргүүлэн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Нэмэлт хэлэлцээрийн тайланг 6 сардаа багтаан газруудаас тайланг хүлээн авна. Хавсралт: 2 файл | | |
| 4.2.30 | Сайд, Төрийн нарийн бичгийн даргын шуурхай хурлыг зохион байгуулах; | - | Удирдлагын шуурхай хурлаас өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийн хувь | 2024 онд зохион байгуулсан хурал, үүрэг даалгаврын биелэлтийн хувь | Сайд, Төрийн нарийн бичгийн даргын шуурхай хурлыг зохион байгуулсан байна. | Сайд, Төрийн нарийн бичгийн даргын шуурхай хурлыг зохион байгуулсан байна. | 2025 оны 01 сарын 06, 01 сарын 20, 01 сарын 27, 02 сарын 10, 02 сарын 17, 03 сарын 10, 03 сарын 17, 2025 оны 04 сарын 01, 2025 оны 04 сарын 17, 04 сарын 22, 05 сарын 06, 05 сарын 19-ны өдрүүд буюу нийт 12 удаагийн сайдын шуурхайг зохион байгуулж, хурлын бэлтгэл ажлыг хангаж ажилласан. 1. ШУУРХАЙ ХУРЛЫН ЗОХОИН БАЙГУУЛАЛТ Эхний хагас жилд нийт 11 удаагийн шуурхай хурлын техникийн бэлэн байдлыг хангаж, хурлыг саадгүй, чанартай зохион байгуулахад шаардлагатай бэлтгэл ажлыг бүрэн гүйцэтгэсэн. Хурлуудыг Microsoft Teams, Zoom зэрэг платформуудыг ашиглан зохион байгуулсан бөгөөд холболтын тогтвортой байдал, тоног төхөөрөмжийн ажиллагаа, дүрс болон дууны чанарт анхаарч ажиллав. 2.ТЕХНИКИЙН БЭЛТГЭЛ, ИЛТГЭЛИЙН ДАРААЛАЛ -Хурал бүрийн өмнө илтгэгч байгууллага, хэлтэс нэгжүүдтэй уялдан бүх илтгэл, танилцуулгыг урьдчилан авч, хуралд танилцуулах дараалалд | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | оруулж, хурал удирдаж буй албан тушаалтанд хүлээлгэн өгсөн. -Илтгэлүүдийг формат стандартын дагуу нэгтгэж, танилцуулахад хялбар, ойлгомжтой байдлаар бэлтгэн танилцуулсан. -Хурал эхлэхийн өмнө техник хангамж (зөөврийн компьютер, дэлгэц, проектор, микрофон, камер)-ийн туршилтыг хийж, алдаа доголдолгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн. 3. ӨРГӨТГӨСӨН ШУУРХАЙ ХУРАЛ, ЦАХИМ ХОЛБОЛТ -Нэг удаагийн өргөтгөсөн шуурхай хурлыг цахим хэлбэрээр амжилттай зохион байгуулсан. -Уг хуралд 21 аймгийн боловсролын газрын дарга нарыг Microsoft Teams ашиглан амжилттай холбож, дуу, дүрсний чанар, холболтын хурд зэргийг хянан ажиллав. -Холболтын өмнө урьдчилан туршилт хийж, бүхий л оролцогч талуудыг хурлын платформд амжилттай холбох дэмжлэг үзүүлэв. -Аймаг бүрийн техникийн нөхцөл байдлыг үнэлэн шаардлагатай оролцогчдод шууд заавар, зөвлөгөө өгч, шуурхай нэвтрэх боломжоор хангаж ажилласан. 4.ХУРЛЫН ДАРААХ МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭЛТ -Шуурхай хуралд танилцуулсан бүх илтгэл, материалуудыг нэгтгэн, яамны удирдлагын Teams группэд байршуулав. -Оролцсон албан | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тушаалтнуудын албан ёсны и-мэйл хаягт хүргүүлж ажилласан. Хавсралт: 10 файл | | |
| 4.2.31 | Боловсролын яамны мэдээллийн аюулгүй байдлын дотоод журмын дагуу мэдээллийн нэгдсэн сүлжээ, интернэтийн дотоод болон wifi сүлжээ, албан хаагчдын цахим шуудангийн тасралтгүй хэвийн ажиллагааны зохицуулалтыг хангаж түүний аюулгүй байдал, хэвийн найдвартай ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах; | - | зохион байгуулсан ажлын тоо | 2024 онд хэрэгжүүлсэн ажлын тоо | Боловсролын яамны мэдээллийн нэгдсэн сүлжээ, интернэтийн дотоод болон wifi сүлжээ, албан хаагчдын цахим шуудангийн тасралтгүй хэвийн ажиллагааны зохицуулалтыг хангаж ажилласан байна. | Боловсролын яамны мэдээллийн нэгдсэн сүлжээ, интернэтийн дотоод болон wifi сүлжээ, албан хаагчдын цахим шуудангийн тасралтгүй хэвийн ажиллагааны зохицуулалтыг хангаж ажилласан байна. | 1. Мэдээллийн нэгдсэн сүлжээний хэвийн ажиллагааг хангах -Яамны төв сервер, чиглүүлэгч төхөөрөмжүүд, дотоод сүлжээний төхөөрөмжүүдийг тогтмол хянаж, тоног төхөөрөмжийн ачаалал, ажиллагаанд өдөр тутмын мониторинг хийв. -Серверийн өрөөний орчны хяналт, хөргөлт, цахилгаан тэжээлийн тогтвортой байдалд хяналт тавьж, доголдлын үед шуурхай сэргээх горимыг мөрдөн ажилласан. -Яамны үндсэн дотоод сүлжээний тоног төхөөрөмжүүдийн (switch, router, firewall) firmware шинэчлэлтийг улирал тутам хийж, системийн гүйцэтгэлийг сайжруулав. 2. Интернэт болон Wi-Fi сүлжээний ажиллагаа -Яамны үндсэн болон туслах Wi-Fi сүлжээнүүдийн ажиллагаанд өдөр бүр хяналт тавьж, сүлжээ тасалдах, хурд унах асуудлыг бууруулах чиглэлээр системийн тохиргоо шинэчлэлт хийсэн. -Сайд, ТНБД, Сайдын зөвлөх, ТЗУГ даргын өрөөнүүдэд Unvivision тусгай сүлжээ нэвтрүүлэв - 1,4,5 дугаар давхруудад байрлах Wi-Fi холболтын хүрээг 4.5 аас 5 руу тэлж, сүлжээний хамрах хүрээг | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сайжруулсан. -Wi-Fi сүлжээнд хандалтын түвшинг тодорхойлж, зөвхөн албан ёсны төхөөрөмжүүд холбогдох эрхтэй байдлаар MAC хяналтын систем нэвтрүүлэв. -Интернэтийн хурдны гүйцэтгэлийг долоо хоног бүр хянаж, үйлчилгээ үзүүлэгчтэй уялдуулан техникийн сайжруулалт хийсэн. 3. Цахим шуудангийн үйлчилгээний зохицуулалт -Боловсролын яамны нийт албан хаагчдын Microsoft Outlook / Exchange дээр суурилсан цахим шуудангийн үйлчилгээний тасралтгүй ажиллагааг хангаж ажилласан. -Шинээр томилогдсон болон ажлаас чөлөөлөгдсөн 18 албан хаагчийн имэйл хаяг үүсгэх, эрх цуцлах, чиглүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. -Имэйл серверийн ачааллыг хянаж, спам, халдлагын эрсдэлээс урьдчилан сэргийлэх антиспам болон хамгаалалтын тохиргоог шинэчлэн нэвтрүүлсэн. -Outlook холболтын доголдол, имэйл илгээх, хүлээн авахтай холбоотой нийт 220 асуудлыг хэрэглэгчийн түвшинд шийдвэрлэж, хэрэглэгчдэд дэмжлэг үзүүлэв.<br>Хавсралт: 3 файл | | |
| 4.2.32 | Яамны вэб сайтыг | - | Веб сайтад оруулсан | 2024 онд Веб сайтад | Яамны вэб сайтыг | Яамны вэб сайтыг | 1.ВЭБ САЙТЫН ХӨГЖҮҮЛЭЛТ, ДЭД ДОМЭЙНУУД ҮҮСГЭХ - | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хөгжүүлэх, мэдээллийн баяжилтад хяналт тавьж ажиллах; | | мэдээллийн тоо | оруулсан мэдээлэл | хөгжүүлж, цаг үеийн мэдээ мэдээллийг тухай бүр сайтад байршуулж олон нийтэд хүргэсэн байна. | хөгжүүлж, цаг үеийн мэдээ мэдээллийг тухай бүр сайтад байршуулж олон нийтэд хүргэсэн байна. | moe.gov.mn үндсэн цахим хуудсыг сайжруулан, агуулгын ангилал, ил тод байдлын бүтэц, UI/UX дизайны сайжруулалт хийсэн. -Монгол бичгийн хувилбар: mon.moe.gov.mn дэд домэйн үүсгэн ажиллуулж, төрийн албан ёсны бичгийн хэлбэрт нийцсэн мэдээллийг нийтэлж эхэлсэн. -Англи хэлний хувилбар: en.moe.gov.mn дэд домэйнд гадаад хэрэглэгчдэд зориулсан орчуулгатай контент, салбарын бодлого, судалгаа, олон улсын хамтын ажиллагааны мэдээллийг байршуулах ажлыг зохион байгуулсан. -Gov.mn сайт дахь мэдээллийг бүртгэж, харьяа байгууллагын админуудад эрх олгон, Viber группээр заавар, зөвлөгөө өгч ажиллалаа. 2. МЭДЭЭЛЛИЙН НИЙТЛЭЛ, ТҮГЭЭЛТ -Тайлагнаж буй хугацаанд нийт 240 удаагийн мэдээ, нийтлэл, зар мэдээ, мэдээллийг тухай бүрд бэлтгэн, вэб сайт болон холбогдох дэд домэйнуудад байршуулав. -Үүнд: арга хэмжээний зар, хурал семинарын тов, удирдамж, бодлогын баримт бичиг, хэвлэлийн мэдээ, тайлан, зурагт мэдээ зэрэг багтсан. -Цаг үеийн шинжтэй, онцгой анхаарал татсан мэдээллийг нүүр хуудсанд онцлон байршуулж, олон нийтэд хүрэх хүртээмжийг нэмэгдүүлсэн. 3. ИЛ ТОД | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | БАЙДЛЫН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ -Монгол Улсын Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 68 заалтын хүрээнд вэб сайтын бүтцийг дахин зохион байгуулж, тухайн заалт бүрийн хүрээнд хамаарах мэдээллийг ангилж, тусгай цэс болон дэд цэстэй байдлаар байршуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. -Мэдээлэл бүрийг хууль, тогтоомжийн үндэслэл, огноо, эх сурвалж, хариуцсан нэгжийн мэдээлэлтэй хавсаргаж оруулсан. -Мэдээллийг шинэчлэх, хугацаат тайлан байрлуулах, архивлах ажиллагаа тогтмол хийгдэж байна. 4. ҮЗҮҮЛЭЛТ, ХАНДАЛТЫН СТАТИСТИК -Тайлант хугацаанд вэб сайтын хандалт, хэрэглэгчийн идэвх, хүртээмжийн үзүүлэлт: -Нийт хандалт (Page views): 554,185 удаа -Давхардаагүй хандалт (Unique users): 260,726 хүн -Өдөрт дунджаар ~3,000–5,000 хэрэглэгч хандсан бөгөөд мэдээллийн шуурхай байдал, сэдвийн ач холбогдлоос хамааран оргил хандалт 15,000 гарсан тохиолдол бүртгэгдсэн. Хавсралт: 6 файл | | |
| 4.2.33 | Яамны цахим мэдээлэл | - | Хэрэгжүүлсэн ажлын тоо | 2024 онд хэрэгжүүлсэн ажлын тоо | Яамны цахим мэдээлэл | Яамны цахим мэдээлэл | 1.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ 2025 оны эхний хагас жилд яамны үндсэн цахим мэдээлэл | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | агуулагдаж буй сервер, тоног төхөөрөмжийн хэвийн, аюулгүй ажиллагааг хангаж, мэдээллийн сангийн хуулбарыг тогтмол хийн, аюулгүй байдлыг хангах; | | | | агуулагдаж буй сервер тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа аюулгүй байдал хангагдсан байна. | агуулагдаж буй сервер тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа аюулгүй байдал хангагдсан байна. | агуулагдаж буй сервер, сүлжээний тоног төхөөрөмжийн хэвийн, аюулгүй ажиллагааг тогтмол хянаж, найдвартай ажиллах нөхцөлийг бүрдүүлэн ажилласан. Мэдээллийн сангуудын найдвартай ажиллагаа, тасралтгүй үйлчилгээ үзүүлэх зорилгоор шөнийн 12:00 цагт автоматаар сервер хооронд өгөгдөл нөөцлөх тохиргоог хийж, 2 серверийн хооронд backup системийг тасралтгүй ажиллуулж байна. 2. СЕРВЕР, СИСТЕМИЙН БҮТЭЦ, АШИГЛАЛТ Яамны мэдээллийн технологийн систем нь дараах үндсэн сервер болон дэд системүүдэд хуваарилагдсан бөгөөд Dell R740 загварын хоёр үндсэн сервер ашиглан дараах чухал системүүдийг багтаасан: № Системийн нэр Тайлбар 1 Авто зогсоолын систем /Байгууллагын дотоод зогсоолын нэвтрэлтийн хяналт/ 2 Microsoft Active Directory (AD) /Албан хаагчдын эрх, нэвтрэх хандалтын төвлөрсөн удирдлага/ 3 Цаг бүртгэлийн систем /Албан хаагчдын ирц, ажлын цаг бүртгэх зориулалттай/ 4 Санхүүгийн систем /Байгууллагын санхүүгийн бүртгэл, тайлан, тооцоолол/ 5 Ирсэн болон явсан бичгийн архивын систем /Албан бичгийн удирдлагын бүртгэл/ 6 Дундын Share фолдер (File server) /Албан хаагчдын дундын | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэрэглээний файл хадгалалт/ 7 E-Content бааз /Цахим сургалтын контент болон хэрэглэгчийн мэдээллийн сан/ 3.АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХЭВИЙН АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ - Серверүүдийн техник үзүүлэлт, ачаалал, температур, дискний ашиглалт, CPU/RAM гүйцэтгэлийг тогтмол хяналттай байлгаж, шаардлагатай тохиолдолд серверийг ачаалал тэнцвэржүүлэлтийн дагуу тохируулан ажиллуулсан. - Windows Server, Active Directory болон мэдээллийн сангууд дээр тогтмол нөхөн шинэчлэлтүүдийг суулгаж, системийн ухаалаг хамгаалалтыг хадгалсан. - галт ханын хамгаалалт , сэжигтэй сүлжээний урсгалыг автоматаар илрүүлж, хязгаарлах зохицуулалттай.<br>4.МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ХУУЛБАРЛАЛТ /BACKUP/ Dell R740 загварын хоёр серверийн хооронд өгөгдлийн автоматаар давхар хуулбарлалтын (redundant backup) тохиргоог хийж, шөнийн 12:00 цагт бүх системүүдийн өгөгдөл автоматаар backup хийгдэж байна.<br>Хавсралт: 1 файл | | |
| 4.2.34 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, | - | Хөдөлмөрийн аюулгүй байдал, | 2024 онд хэрэгжүүлсэн арга | Хөдөлмөрийн аюулгүй байдал, | Хөдөлмөрийн аюулгүй байдал, | 1. Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/91 тоот | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг яамны хэмжээнд зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллах; | | эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр зохион байгуулсан ажлын тоо | хэмжээ | эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна | эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна | тушаалаар Боловсролын салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооны бүрэлдэхүүнийг батлуулсан. 2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооны судалгааг бөглөн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвд хүргүүлсэн. 3. Хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтны эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдлыг хамгаалах төрийн бодлого зарчмыг хэрэгжүүлэх, үр нөлөөтэй нийгмийн түншлэлийг хөгжүүлэх зорилгоор "Ажил олгогч, удирдах ажилтны сургалт" авах хүсэлтийг 2025.04.18 өдрийн 12/1595 тоот албан бичгээр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвд хүргүүлсэн. 4. "Эрүүл аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага-2024 болзолт уралдаан" -ы хоёрдугаар шатны шалгаруулалт хийх ажлын хэсэгт ажилласан. Нийт 22 байгууллага материал ирүүлсэн бөгөөд үнэлгээний хуудсын дагуу 58 үзүүлэлтээр Төв аймгийн Политехникийн коллеж, ерөнхий боловсролын Хобби сургууль, Баянхонгор аймгийн Политехникийн коллеж, Баянхонгор аймгийн Эрдэм ахлах сургууль, Баянхонгор аймгийн Гэгээн сумади сургууль, цэцэрлэгийн цогцолборийн үнэлгээг хийсэн. 5. Хөдөлмөрийн | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний III чуулган"-д оролцсон. 6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян-2025 нээлтийн арга хэмжээнд оролцсон. Хавсралт: 4 файл | | |
| 4.3. | Яамны болон салбарын мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллана. | - | - | - | - | | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан чиглэлээр ил тод байдлыг хангаж ажилласан. | 100% | 100 % |
| 4.3.1 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах | - | 2025 онд мэдээлсэн мэдээллийн тоо | 2024 онд цахим системд байршуулсан мэдээллийн тоо | Шилэн дансны тухай хуульд заасан заасан мэдээ мэдээллийг цахим системд байршуулж хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Шилэн дансны тухай хуульд заасан заасан мэдээ мэдээллийг цахим системд байршуулж хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Нийтийн мэдээллийн ил тод байдлын хууль болон шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан. Тайлант хугацаанд нийт 6 удаа буюу сар тутам шилэн дансанд санхүүгийн мэдээллүүдийг байршуулж ажилласан. Хавсралт: 3 файл | 100% | 100 % |
| 4.3.2 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, | - | цахим системд байршуулсан мэдээллийн тоо | 2024 онд цахим системд байршуулсан мэдээллийн тоо | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээллийг цахим | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээллийг цахим | 1. НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХҮРЭЭНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ 2025 оны эхний хагас жилд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйл, | 100% | 90 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хяналт тавих | | | | системд байршуулж хэрэгжилтийг ханган ажилласан байна. | системд байршуулж хэрэгжилтийг ханган ажилласан байна. | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан журмын хэрэгжилтийг хангах зорилгоор дараах ажлуудыг үе шаттайгаар хийж гүйцэтгэлээ. Үүнд: 1.1. ИЛ ТОД МЭДЭЭЛЛИЙН ТӨВЛӨРСӨН ЦУГЛУУЛАЛТ -Газар, хэлтэс нэгжүүдэд дотоод албан бичгээр чиглэл өгч, ил тод байлгах ёстой мэдээллүүдийг нэгдсэн байдлаар цуглуулах, хуваарилах ажлыг зохион байгуулсан. -Ил тод мэдээллийн бүлэглэлийг 8 дугаар зүйлийн хүрээнд 86 шалгуур үзүүлэлтээр ангилан, тус бүрээр Share (дундын) хавтас үүсгэж, хариуцсан нэгжүүдэд холбох, байрлуулах зааварчилгаа өгсөн. -Албан хаагч бүрийн мэдээлэл байршуулалт, хариуцлагын зааг тодорхой болгож, нэгдсэн хяналтад авсан. 1.2. SHILEN.GOV.MN СИСТЕМД МЭДЭЭЛЭЛ БАЙРШУУЛАЛТ - "shilen.gov.mn" ил тодын нэгдсэн системд нийт 86 заалтын дагуу тайлагнал хийгдсэн. -Мэдээллийг байршуулсан линк, баримт бичгийн дугаар, огноо, эх сурвалжийг хяналтын хүснэгтэд тэмдэглэн, тайланг бүрдүүлж нэгж бүрд хүргүүлсэн. -Хугацаат мэдээллийн хувьд шинэчлэлтүүдийг тухай бүрт оруулан, өмнөх улирлуудын мэдээлэлтэй уялдуулан боловсруулсан. -Ил тод | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | мэдээллийг байршуулах талаар эрчимжүүлсэн дотоод зохион байгуулалт хийж, хэрэгжилтийн хяналтыг үе шаттайгаар үнэлсэн. 2. СУДАЛГААНЫ НЭГДСЭН СИСТЕМ /SUDALGAA.GOV.MN/ 2025 оны хагас жилд төрийн болон орон нутгийн хөрөнгөөр хийсэн судалгааны тайлагналын хүрээнд: -Үндэсний судалгааны нэгдсэн платформ (sudalgaa.gov.mn) системд тайлагнах судалгааны мэдээллийг холбогдох нэгжүүдээс авч нэгтгэж, 2 төрлийн судалгааны мэдээллийг амжилттай байршуулсан. -Судалгааны нэр, санхүүжилтийн эх үүсвэр, гүйцэтгэгч байгууллага, тайлангийн хугацаа, дүн шинжилгээ, үр дүнг тусгасан бүрэн материал бүхий PDF хэлбэртэй баримтыг хавсаргасан. -Судалгааны ил тод байдлыг хангах үүднээс тухайн мэдээлэлд хамаарах линк, тайлангийн хураангуйг англи, монгол хэл дээр байршуулж, системд нийцүүлсэн<br>Хавсралт: 3 файл | | |
| 4.4. | Төрийн захиргааны төв байгууллагын болон харьяа байгууллагы | - | - | - | - | | Төрийн захиргааны төв байгууллагын болон харьяа байгууллагын хүний нөөцийн удирдлагын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийг хангах, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж ажилласан. | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | н хүний нөөцийн удирдлагын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийг хангах, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана. | | | | | | | | |
| 4.4.1 | Салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомжийн болон түүний үзэл баримтлалын төслийг боловсруулах, сайд, яамны Төрийн нарийн бичгийн | үйл ажиллагааны зардлаар | 1.Мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн захиргааны хэм хэмжээний актын тоо. 2.Мэдээллийн сангийн баяжуулалтын хувь | 2024 онд сурталчилсан хууль тогтоомжийн тоо | 1. Хууль, эрх зүйн мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн байна. 2. Тушаал, гэрээ, хэлэлцээрийн төслийг бусад хууль тогтоомжид нийцүүлэн хянасан байна. 3.Захиргааны хэм хэмжээний актыг мэдээллийн | 1. Хууль, эрх зүйн мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн байна. 2. Тушаал, гэрээ, хэлэлцээрийн төслийг бусад хууль тогтоомжид нийцүүлэн хянасан байна. 3.Захиргааны хэм хэмжээний актыг мэдээллийн | 1. Сайд, Төрийн нарийн бичгийн даргын нийт 382 тушаалын төслийг хянаж холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх чиглэлээр зөвлөгөө дэмжлэг үзүүлэв. Үүнээс Сайдын А тушаал-126, Б тушаал-56, Төрийн нарийн бичгийн даргын А тушаал -22, Б тушаал-39 байв. Мөн Төрийн албаны зөвлөлийн Боловсролын яамны дэргэдэх салбар зөвлөлийн 56 тогтоолын төсөл хянав. 2. БЯ-аас бусад байгууллага ААН-тэй нийт 236 гэрээний төсөл хянаж эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж ажилласан байна. 3. Засгийн газрын хуралдаанд танилцуулж хэлэлцүүлэх, батлах 20 шийдвэрийн төслийг хянаж эрх зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлж ажилласан. 4. Тайлант | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | даргын тушаал, гэрээ, хэлэлцээрийн төслийг бусад хууль тогтоомжид нийцүүлэн хянах, салбарын захиргааны хэм хэмжээний актын мэдээллийн санг эрхлэн хөтлөх, хөдөлгөөний г тогтмол бүртгэх, сурталчлах ажлыг зохион байгуулна. | | | | санд баяжуулалт хийгдсэн байна. | санд баяжуулалт хийгдсэн байна. | хугацаанд 9 захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн санд бүртгүүлэхээр хүргүүлснээс 7 журмыг улсын нэгдсэн санд бүртгэсэн. Боловсролын салбарт улсын нэгдсэн санд бүртгэлтэй 64 захиргааны хэм хэмжээний акт хүчинтэй байна. 5. Боловсролын баг хуулийн хүрээнд Төрийн нарийн бичгийн даргаар батлагдаагүй 11 дүрэм, журмын жагсаалтыг гарган төлөвлөгөө гарган батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 6. Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах тухай анхдагч хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл, төслийн танилцуулга, зардлын тооцоо, судлагаа хуулийн төслийг дагаж Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж ажилласан 7.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан доор дурдсан төсөл, танилцуулгыг боловсруулж гүйцэтгэлээ 8. Захиргааны хуулийн нэхэмжлэлтэй иргэн М.Нямханд, Өмгөөлөгч Ц.Чулуунцэцэгийн нэхэмжлэлтэй Боловсролын сайдын тушаалаар баталсан Багшлах эрхийн гэрчилгээ олгох журмын, Монсудар ХХК-ийн нэхэмжлэлтэй Сурах бичгийн эх | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зохиох бэлтгэх хэвлэн нийлүүлэх журмыг хүчингүй болгох, БШУС-н баталсан Багшлах эрх олгох журмын холбогдох заалтыг хүчингүй болгох зэрэг хууль шүүхийн маргаантай хэрэгт ХЭЗХ-ийн дарга мэргэжилтнүүд орж ажилласан байна.<br>Хавсралт: 1 файл | | |

*Үнэлсэн:* .........................

.......................................... ......................... /................................/

*(албан тушаал )* *(гарын үсэг)*

.........................

*(огноо)*

*Тайлагнасан:* .........................

.......................................... ......................... /................................/

*(албан тушаал )* *(гарын үсэг)*

.........................

*(огноо)*